

# Хишиг

Дараах асуултын хариултыг олж мэдэхээр [Temples.ChurchofJesusChrist.org](https://Temples.ChurchofJesusChrist.org) дээрх дараах мэдээллийг унш.

- Намайг хишгээ хүлээн авахад Их Эзэн хэрхэн адисалдаг вэ?

Та Сүмд нэгдэхдээ баптисм, гишүүний баталгаа гэсэн хоёр ёслолыг хүлээн авдаг. Үүнтэй адил, ариун сүмийн хишгийг хоёр хэсэгтэйгээр хүлээж авдаг.

Эхний хэсэгт та хувьдаа ганцаарчлан “анхдагч” ёслолуудыг хүлээн авна. Эдгээр ёслолд таны тэнгэрлэг өв, чадавхтай холбоотой онцгой адислалууд багтдаг. Эдгээр ёслолын нэг хэсэг болгож танд ариун сүмийн гармент өмсөх эрхийг өгнө.

Та хишгийнхээ үлдсэн хэсгийг хоёр дахь хэсэгт бүлгээр хүлээн авна. Энэ нь ариун сүмд ирдэг бусад хүнтэй хамт зааварчилгааны өрөөнд болдог ба авралын төлөвлөгөөний нэг хэсэг болох үйл явдлуудыг харуулдаг. Үүнд: Бүтээлт, Адам, Ева хоёрын Уналт, Есүс Христийн Цагаатгал, Урвалт, Сэргээлтийг багтаасан байна. Мөн та хүмүүсийн Их Эзэний оршихуйд буцаж очиж болох арга замын талаар илүү ихийг мэдэж авна. Хишгийн зарим хэсгийг видеогоор танилцуулж, заримыг нь ариун сүмийн ажилтнууд танилцуулна.

Таныг хишгийн ёслолын үеэр тодорхой гэрээнүүдийг Бурхантай байгуулахад урих болно. Эдгээр гэрээнд дараах зүйлс орно.

- Бурханы зарлигуудыг дагахаар чин сэтгэлээсээ чармайх хууль болох дуулгавартай байдлын хууль
- Их Эзэний ажлыг дэмжихийн тулд чадах бүхнээ үйлдэж; харамссан зүрх, гэмшсэн сэтгэлтэйгээр наманчлах золиослолын хууль
- Есүсийн дэлхий дээр байхдаа заасан дээд түвшний хууль буюу сайн мэдээний хууль
- Бурханы хуулиар, албан ёсоор, хуулийн дагуу гэрлэсэн хүнтэйгээ л бэлгийн харьцаанд орох буюу ариун явдлын хууль
- Бүх цаг зав, авьяас чадвараа мөн Их Эзэний өөрсдөд нь адислал болгон өгсөн бүхнийг Есүс Христийн Сүмийг дэлхий дээр барьж босгоход зориулах буюу бүхнээ зориулах хууль

Та гэрээнүүдээ сахиснаар Аврагчид илүү ойртож, Түүнтэй харилцах харилцаа тань улам хүчирхэгжинэ. Бурхан гэрээгээ сахисан хүмүүст энэ амьдралдаа адислалуудыг хүлээн авах, Өөртэй нь үүрд хамт амьдрахаар эргэн ирэх боломжийг амладаг.

Хишиг хүртсэнийхээ төгсгөлд оролцогчид селестиел өрөөнд ордог нь Их Эзэний оршихуйд буцаж ирэхийн бэлгэдэл юм. Тэнд та тунгаан бодож, залбирч, судруудыг уншиж эсвэл гэр бүл, найз нөхөдтэйгөө санал бодлоо чимээгүйхэн хуваалцаж болно. Энэ нь тайвшралыг олж, тэнгэрлэг удирдамж авч болох амар тайван газар юм. (“About the Temple Endowment,” [temples.ChurchofJesusChrist.org](https://temples.ChurchofJesusChrist.org)-ийг үзнэ үү).